

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Орхон аймаг


1. Үндсэн үйл ажиллагаа:

Аймгийн Засаг даргын 2025 оны А/17 захирамжаар 12 орон тоотой байгууллагын стратеги төлөвлөгөөний **5 зорилгын** хүрээнд 2026 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг **7 зорилтын** хүрээнд **44 арга хэмжээг** төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.1. Байгууллагын “Эрсдэлийн үнэлгээний журам”-ын дагуу 2026 оны Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан **55** байгууллагаас 2026 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн байдлаар **29** байгууллагын хяналт шалгалт бүрэн дууссан, **5** байгууллагын хяналт шалгалт 20-90%-тай үргэлжилж байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын төрөл:

Он	ДА, СХШ-ын /төлөвлөгөөт +төлөвлөгөөт бус тоо/	2026.06.29-ний өдрөөр батлагдсан удирдамжийн тоо	Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	Дотоод аудит	Санхүүгийн хяналт шалгалт
2026	55+3	37	34	3	24	13



2026 оны 6 дугаар сарын 29-ны өдрөөр төлөвлөгөөт хяналт шалгалтын биелэлт **62%-тай** байна. **Тайлбар:** Хяналт, шалгалтын төлөвлөгөөний биелэлтийг өссөн дүнгээр мэдээллэж байгаа болно.

-Шалгалт бүрэн дууссан байгууллагууд:

1. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ
2. Их шүтээн ОНӨААТҮГ
3. Үйлс бадрах ӨЭМТөв

4. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан
5. 20-р цэцэрлэг
6. 5-р цэцэрлэг
7. 2-р цэцэрлэг
8. 16-р цэцэрлэг
9. Жаргалант сумын хоршоо хөгжүүлэх сан
10. 11-р цэцэрлэг
11. 24-р цэцэрлэг
12. 19-р цэцэрлэг
13. 4-р цэцэрлэг
14. 3-р цэцэрлэг
15. 21-р цэцэрлэг
16. Хотын захирагчийн алба (**төлөвлөгөөт бус**)
17. 10-р цэцэрлэг
18. 4-р сургууль
19. 8-р сургууль
20. “Жаргалант ус дулаан түгээх станц” ОНӨХК (**төлөвлөгөөт бус**)
21. Оюу цэцэрлэг
22. Одод цэцэрлэг
23. Баян-Өндөр сумын ОНХСан
24. Татварын газар
25. 20-р сургууль
26. Гаалийн газар
27. Худалдан авах ажиллагааны газар
28. Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар
29. 1-р сургууль
30. Бялзуухай цэцэрлэг
31. 7-р цэцэрлэг
32. 17-р цэцэрлэг (**төлөвлөгөөт бус**)

Дээрх байгууллагуудын гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт танилцуулж, тогтоосон акт, албан шаардлага, ажил сайжруулах зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд хангуулан ажиллаж байна.


-Шалгалт бүрэн дуусаагүй байгууллагууд:

1. Хот тохижуулах газар
2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан
3. Баян-Өндөр сумын ЗДТГ
4. Жаргалант сумын Болзошгүй аваарын зардал
5. Эрдэнэт сан

Дээрх байгууллагуудын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

- 1.2.** Байгууллагын 2026 оны эхний хагас жилийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т 2026.06.15-ны өдөр хүргүүлсэн.
- 1.3.** Байгууллагад холбогдох 2026 оны эхний хагас жилийн тогтоол шийдвэрийн биелэлтийг 2026.06.17-ны өдөр и-оффис системд шивж оруулсан.
- 1.4.** 05 дугаар сарыг “**Мэргэжлээ сурталчилж, мэдлэгээ хуваалцъя**” уриан дор “**Дотоод аудитыг сурталчлах сарын аян**”-ыг 3 зорилт хүрээнд 9 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж ажилласан. Ажлын тайланг “**Монголын Үндэсний дотоод аудитуудын холбоо**”-д 2026.06.22-ны өдөр хүргүүлсэн.

1.5. Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”, “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn сайтад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нээлттэй мэдээллийг 2026 оны II улирлын байдлаар гаргаж, тайланг илгээсэн.



2. СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН:

Төрийн албаны зөвлөлөөс 4 дүгээр сараас эхлэн 7:4:10 сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Энэ сарын 4 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 19 албан хаагч хамрагдсан. Үүнд:

- 2026.06.04-ний өдөр “Яам, агентлагийн албан хаагчдын боловсрол, мэргэжил, мэргэжил, ажилласан хугацааны дүн шинжилгээ”, “Монгол улсад төрийн албаны чадавх бэхжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний давхардал, хийдэлд хийсэн шинжилгээ” сэдэвт сургалтад 8 албан хаагч
- 2026.06.11-ний өдөр “Аюулгүй байдал-иргэдийн оролцоо хөтөлбөрийн талаарх танилцуулга”, “Үндэсний аюулгүй байдал: когнитив домайн” сэдэвт сургалтад 3 албан хаагч
- 2026.06.18-ны өдөр “Жендэрийн тэгш байдлыг хангах нь: Суурь ойлголт, тулгамдсан асуудал, төрийн үйлчилгээний үр нөлөө” сэдэвт сургалтад 5 албан хаагч
- 2026.06.25-ны өдөр “Монголын хүн амын удмын сангийн аюулгүй байдал тулгамдаж буй зарим асуудал ба төрийн бодлогын залгамж чанар” сэдэвт сургалтад 3 албан хаагч

Бусад холбогдох дээд газраас зохион байгуулсан 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 16 албан хаагчид хамрагдлаа. Үүнд:

- 2026.06.08-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан. “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, авлигатай тэмцэх арга барилд сургах” сэдэвт сургалтад байгууллагын 10 албан хаагч хамрагдлаа.



- 2026.06.10-11-ний өдрүүдэд “Ворлд стандарт консалтинг” ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд “Авлигын эсрэг менежментийн тогтолцоо ISO 37001:2016 олон улсын стандартын дотоод аудитор бэлтгэх” сургалтад Газрын дарга, Ахлах мэргэжилтэн нар хамрагдлаа.



- 2026.06.26-ны өдөр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас зохион байгуулсан “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим, Хүүхэд хамгааллын бодлого” сэдэвт сургалтад байгууллагын Эцэг эхийн зөвлөлийн 2 гишүүн хамрагдлаа.



Байгууллагын 2026 оны Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөгөөт сургалт:

- 2026.06.10-11-ний өдрүүдэд “Ворлд стандарт консалтинг” ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд “Авлигын эсрэг менежментийн тогтолцоо ISO 37001:2016 олон улсын стандартын дотоод аудитор бэлтгэх” сургалтад Газрын дарга, Ахлах мэргэжилтэн нар хамрагдлаа.



3. Үүрэг даалгавар: 6 дугаар сард Засаг даргын өргөтгөсөн шуурхайгаас **3 үүрэг даалгавар** ирснийг хэрэгжилтийг ханган ажилласан. Үүрэг даалгаврын биелэлтийг тогтоосон хугацаанд и-оффис системд хааж, биелэлтийн тайланг аймгийн ХШҮХ-т тухай бүр хүргүүлсэн.

ОНЦЛОХ АЖИЛ, МАНЛАЙЛАЛ:

- Тус газар нь Эрдэнэт хот байгуулагдсаны 50 жилийн ойн арга хэмжээг угтаж хийх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сард Байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг 06 сард 100% ханган ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т албан бичгээр 2026.06.15-ны өдөр хүргүүлж ажилласан.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ЭРДЭНЭТ ХОТ БАЙГУУЛАГДСАНЫ 50 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭГ УГТАЖ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ					Орхон аймаг	
2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр					Орхон аймаг	
№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа	Төсөв	Хэрэгжүүлэх албан тушаалтан	Хүрэн үр дүн	Биелэлтийн хувь
1	Байгууллагын түүхчлсэн архив үүсгэх ажил хийх	2026 оны 05 сард	Ес зүйн дэд хороо хариуца	Ес зүйн дэд хороо	Байгууллагын түүхчлсэн архив үүсгэсэн байна	100%
2	"Эрүүл хамт олон-2026" уриан дор албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих ажил зохион байгуулах	2026 оны 04 сард	Үйл ажиллагааны зардал	Газрын дарга, ХАБЭА хариуца	Урьдчилан сорилгох үзлэлт хамрагдаж, өмчлөлөөс урьдчилан сорилгох байна. Амьдралын энэ дадал хэргийг албан хаагчдын тоо нэмэгдүүлнэ.	
3	Замчиргааны 10 байрны 1 дүрээр дамжсан "Хөгжсөн сансар"-ийг шалгаруулж байгуулах, гэрэлтүүлэх, үүдний хэсгийн хийс, гишүүний шалгаруул	2026 оны 05 сард	Үйл ажиллагааны зардал	Бүх албан хаагч	"Хөгжсөн сансар"-ийг шалгаруулж, гэрэлтүүлж хийсэн байна. Үүдний хэсгийн хийс, гишүүний шалгаруул энэ үзэмж сайжирсан.	
4	Байгууллагын хувиард талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажил хийх	Өдөр бүр	Албан хаагчид хариуца	Бүх албан хаагч	Байгууллагын хувиард талбайд албан хаагчид тоогоор мод таслан байна.	
5	"Хөгжсөн сансар"-ийн алба-ны албан хаагчидтай нөхцөл спортын 2	2026 оны 05 сард	Ес зүйн дэд хороо	Ес зүйн дэд хороо	2 байгууллагын албан хаагчдын координд хяналта, хамтын	

- 2026.06.15-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдад Газрын дарга **"Нэгдсэн менежментийн тогтолцоо"** хэрэгжүүлсэн сайн туршлагаа хуваалцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.



Орхон аймгийн Улаан Загалмайн Хорооны ажлын алба, Хорооны дэргэдэх Донорын зөвлөлөөс "Дэлхийн цусны донорын өдөр"-ийг угтан "614+614..." аяныг зохион байгуулах хүмүүнлэгийн үйлсэд манлайлан оролцсон тул 2026.06.17-ны өдөр Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгийн **"Донор сурталчлагч"** батламжаар шагнууллаа.



7 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЖЛУУД:

- Төлөвлөгөөт хяналт шалгалтууд хуваарийн дагуу явагдана.
- Цаг үеийн болон төлөвлөгөөт бус байгууллагад холбогдох арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцоно.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР